



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

«Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа»
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.5, 19.18 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 03 дугаар хурлаас гарсан саналын дагуу эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 13 хуулийн этгээдийн жагсаалтыг 1 дүгээр, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хуулийн этгээдийг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхыг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг энэ тушаалын 1 дүгээр хавсралтад заасан хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын 1 дүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг комиссын ажлын албанд, тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Э.Есү)-т, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Статистик мэдээлэл, цахим эрүүл мэндийн хэлтэс (Н.Долгормаа)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга (П.Даваатөмөр)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЭН



Д.ЦЭНД-АЮУШ

1150500257


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн
17/21 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГОАЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1	“Ачит чагнуур” ББН /6881955	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	Өрхийн эрүүл мэндийн төв	Баянзүрх дүүргийн 29 дүгээр хороо, Дунд Дарь эх, Сэлбэ өөрийн байр
2	“Энх тунх өрх” ББН /6858104/	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	Өрхийн эрүүл мэндийн төв	Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо 106/8-р байрны 1 дүгээр давхар
3	“Номгон жаргалант” ББН /6845665/	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ	Өрхийн эрүүл мэндийн төв	Баянзүрх дүүргийн 31 дүгээр хороо, Монелийн 5-687 тоот
4	Билэг ундарга ХХК /6096905/	Клиник	Эмэгтэйчүүдийн өвчний оношилгоо, эмчилгээ	Баянгол дүүргийн 18 дугаар хороо, 4 дүгээр хороолол, ММС бьюлдинг 608 тоот
5	Баян дэлгэрэх од ХХК /6306098/	Клиник	Эмнэлзүйн лабораторийн оношилгоо	Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Хүннү гудамж, 420/9 байр, 04 тоот
6	Фючери смайл ХХК /6726542/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ	Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо, 19-р хороолол, Нэхмэлийн орон сууцны 5-р байр, үйлчилгээний төвийн 208 тоот
7	Прокариот ХХК /6687458/	Клиник	Эмнэлзүйн лабораторийн оношилгоо, микробиологийн лабораторийн оношилгоо	Сонгинохайрхан дүүргийн 38 дугаар хороо, Ач анагаах ухааны их сургуулийн 2-р байр
8	Самсем дижитал мед ХХК /6845924/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, гажиг засал, согог засал, нүүр амны мэс засал	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсан центр 3 давхарт
9	Ачлалт хэрсэн ХХК /5126738/	Клиник	Дотрын өвчний оношилгоо, эмчилгээ, хэт авиан оношилгоо	Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороо, Энэрэл манал эмнэлгийн 202, 205 тоот
10	Юу жаспер дентал клиник ХХК /8323607/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, гажиг засал, согог засал, нүүр амны мэс засал	Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, 14-р хороолол, 103-р байр, 146 тоот

11	Ичээтэй жаран нуруу ХХК /6296157/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, гажиг засал, согог засал, нүүр амны мэс засал	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Намъяанжугийн гудамж, Борх төвийн 2 давхарт 201 тоот
12	Маранта фарм ХХК /6229824/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Баянгол дүүргийн 6 дугаар хороо, Бичил хороолол, 13-р байрны 73 тоот
13	Сөдхөн төгс ХХК /6998305/	Эмийн сан	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо, 18073 Москвагийн гудамж, Драгон төв

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн
11/21 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	"Нэмэр фарм" ХХК /6669425/	Эмийн сан	ЭСХ-22/22/4441